



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/146

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Амь халуун уул” шинэ цомгийн баяр, тоглолтоо нутгийн зон олондоо толилуулж буй Ховд нутгийн унаган хүү, Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын дуучин Н.Төмөрсүх, Торгууд өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн авъяас билгээ дайчлан ажиллаж буй дуучин Б.Батболд нарыг аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнахад 700000, “Мянган ээжийн баяр” дуун цэнгүүнийг аймагт амжилттай зохион байгуулсан Монгол Улсын гавъяат жүжигчин Л.Чаминчулуун, С.Вандан, Д.Дуламсүрэн нарыг урамшуулахад 75000 төгрөгийг тус тус хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 775000 төгрөг /долоон зуун далан таван мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 07-ны өдрийн
А/146 дугаар захирамжийн хавсралт



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ БОЛОН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ХҮМҮҮСИЙН НЭРС**

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Н.Төмөрсүх	УДБЭТ-ын дуучин	500000
2	Б.Батболд	Дуучин	200000
3	С.Вандан	Монгол улсын гавъяат жүжигчин, дуучин	25000
4	Д.Дуламсүрэн	Монгол улсын гавъяат жүжигчин, дуучин	25000
5	Л.Чаминчулуун	Монгол улсын гавъяат жүжигчин	25000
Дүн			775000

-оОо-